

Судалгааны Тойм

№29 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

ЯПОН УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

СУДАЛГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулийн 6.2 дахь хэсгийн “төрийн өмч” гэсэн томъёоллыг “төрийн нийтийн өмч” гэж өөрчлөн найруулсан байна. Уг нэр томъёоны “цаад агуулга нь Монголын ард түмний нийтлэг ашиг сонирхол буюу нийтийн ашиг сонирхлын үүднээс газар, байгалийн баялгийн хувь заяаг шийдвэрлэнэ”¹ гэсэн утгатай.

Энэхүү Үндсэн хуулийн хэвшсэн нэр томъёог “төрийн нийтийн өмч” болгон өөрчлөх болсон үйл явцын ард төрийн өмчийн удирдлага, эрх зүйн зохицуулалт өнөөг хүртэл хангалтгүй байснаас үүдэн төрийн өмчийг хувийн ашиг сонирхлын үүднээс захиран зарцуулах, үр ашиггүй болгох “нийтийн өмчийн эмгэнэл” (*tragedy of the commons*)-ийн асуудал өргөн хүрээнд үүссэнтэй холбоотой байж болно. Түүнчлэн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг дагалдан ердийн хуулийн шинэчлэл хараахан хийгдээгүйн улмаас төрийн өмчийг харилцааг зохицуулж буй холбогдох хууль тогтоомж Үндсэн хуультай зөрчилдөх болсон. Тухайлбал, 1996 оны Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4.4-т “Төрийн нийтийн

зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн (Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн), бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно” гэх заалтыг дурдаж болох юм. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн шинэчлэхээс гадна “нийтийн өмчийн эмгэнэл”-ийг арилгах хүрээнд төрийн бүхий л төрлийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Энэ хүрээнд Япон Улсын туршлага, эрх зүйн зохицуулалтыг судалсан бөгөөд тус улс нь 1918 онд Төрийн өмчийн тухай хууль баталж, уг хуулийг хэрэгжүүлэх хугацаанд хуримтлуулсан туршлагадаа тулгуурлан 1948 оноос төрийн өмчийн талаарх багц хууль боловсруулан гаргажээ. Үүнд:

- 1) Төрийн өмчийн тухай хуулийн хууль (1948);
- 2) Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай хууль (1955);
- 3) Эд зүйлсийн удирдлагын тухай хууль (1956) хамаарна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ЗӨВЛӨМЖ

Япон Улсын төрийн өмчийн хууль тогтоомжид хийсэн судалгааны гол үр дүнг багцлан харуулбал:

1) Төрийн өмч, түүний эрх зүйн зохицуулалт

Төрийн өмч нь олон төрлийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд хөрөнгө бүрийн зориулалт, онцлогоос шалтгаалан ялгамжтай удирддаг. Тухайлбал, төрийн өмчийн

хөрөнгийг дараах байдлаар ангилан ялгамжтай зохицуулжээ:

- Бэлэн мөнгө;
- Төрийн өмчийн тухай хууль дахь хөрөнгө (голлох хөрөнгө);
- Эд зүйлс (зарим хөдлөх хөрөнгө);
- Шаардах эрх.

¹ О.Мөнхсайхан, ikon.mn-д өгсөн ярилцлага, 2020.06.19. [<https://ikon.mn/n/1x1c>]

Төрийн өмчийн бэлэн мөнгийг удирдах, захиран зарцуулахад чиглэсэн бие даасан хууль байхгүй бөгөөд Төсвийн орлого, зарлагын тухай хууль үйлчилнэ. Харин төрийн бусад өмчийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, үнэт цаас, оюуны өмч, эд зүйлс, шаардах эрхийн хувьд бие даасан хуулиар зохицуулдаг. Мөн Төрийн өмчийн тухай хууль дахь хөрөнгийг удирдах, захиран зарцуулахад чиглэсэн тусгай харилцааг зохицуулсан олон бие даасан хууль үйлчилдэг. Ийнхүү төрийн өмч, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд Япон Улсын нэгэн адилаар төрийн өмчийн бүхий л хөрөнгөд хамаарах ерөнхий хууль болон хөрөнгийн онцлогтой уялдуулсан эрх зүйн зохицуулалтыг ялгамжтай, үе шаттайгаар батлан хэрэгжүүлэх нь оновчтой байж болно.

2) Төрийн өмчийн тухай хууль дахь төрийн өмчийн ангилал

Төрийн өмчийн тухай хууль нь төрийн өмчийг түүний удирдлага, захиран зарцуулалтын онцлогоос хамааран дараах байдлаар ангилсан байна:

- Захиргааны өмч;
- Ердийн өмч.

Улмаар захиргааны өмчийн хөрөнгийг захиран зарцуулах харилцаанд тодорхой хязгаарлалт тавьсан. Харин ердийн өмчийн хөрөнгийн хувьд түүний үр ашигтай байдалд илүү ач холбогдол өгч, түүнийг захиран зарцуулах асуудлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн. Мөн захиргааны өмчид хамаарах хөрөнгийг түүний онцлогоос шалтгаалан дараах дөрвөн төрөлд хуваасан:

- Албаны өмч;
- Нийтийн өмч;
- Хааны гэр бүлийн өмч;
- Аж ахуйн зориулалтай өмч.

Энэхүү ангилалтай уялдуулан тухайн хөрөнгийг удирдах байгууллага, захиран зарцуулах харилцааг ялгамжтай зохицуулсан. Тухайлбал, гол горхи, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн талбай зэрэг нийтийн өмчид хамаарах хөрөнгийн зориулалтыг өөрчлөхөд Парламентаар хэлэлцүүлэх шаардлага тавьсан.

Ийнхүү төрийн өмчийн ангилал бий болгон, тухайн ангилалд үндэслэн удирдах, захиран зарцуулах харилцааг ялгамжтайгаар тогтоосон нь эрх зүйн зохицуулалтын хувьд оновчтой байж болохоор байна.

3) Төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах

Ердийн өмчид хамаарах хөрөнгийг үр ашигтай удирдах үүднээс хуульд заасны дагуу захиран зарцуулах боломжийг нээлттэй үлдээсэн. Тухайлбал, ердийн өмчийг захиран зарцуулах хүрээнд худалдах, түрээслэх, хөрөнгө итгэмжлэх замаар эргэлтэд оруулах, шилжүүлэн олгох зэрэг олон аргыг бие даасан хуулиар нарийвчлан зохицуулжээ. Харин захиргааны өмч нь захиргааны үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хөрөнгө тул захиран зарцуулах асуудлыг хязгаарлаж, захиран зарцуулах тохиолдолд ердийн өмчид шилжүүлэх зарчмыг тогтоосон байна. Ийнхүү төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах асуудлыг төрийн өмчийн ангилалд үндэслэх замаар төрийн өмчийн удирдлагын харилцааг оновчтой, үр ашигтай явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

4) Онцлог хөрөнгийг удирдах, захиран зарцуулах

Япон Улс нь Төрийн өмчийн тухай хуулиас гадна төрийн өмчийн эд зүйлс, шаардах эрх зэрэг онцлог хөрөнгийн удирдлагын хүрээнд Эд зүйлсийн удирдлагын тухай, Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай зэрэг бие даасан хуулиудыг баталжээ. Энэ нь тодорхой төрлийн хөрөнгийг онцлогт нь нийцүүлэн ялгамжтай удирдах, захиран зарцуулах, оновчтой механизм бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.

5) Төрийн өмчийн тайлагнал, ил тод байдал

Японы яам, агентлагууд харьяалагдах хөрөнгөө бүртгэж, Сангийн сайдад хүргүүлнэ. Сангийн сайд нь яам, агентлагийн тайланг нэгтгэн “Төрийн өмчийн өнөөгийн үнэлгээний тайлан”, “Төрийн өмчийн өөрчлөлтийн тайлан”, “Төрийн өмчийг хариу төлбөргүй түрээслүүлсэн байдлын тайлан” зэргийг үе шаттайгаар тогтмол боловсруулж, Парламентад тайлагнах тогтолцоо бий болгожээ. Энэ нь Засгийн газраас төрийн өмчийн өнөөгийн нөхцөл байдлын талаар тодорхой ойлголттой болохоос гадна Парламентад ард түмний төлөөллийн хувиар төрийн өмчид хяналт тавих боломж олгодог. Мөн төрийн өмчийн олон нийтийн мэдээллийн сан үүсгэснээс гадна төрийн өмчийн талаарх бүхий л тайлан, статистик, хэлэлцүүлэг зэрэгт холбогдох мэдээллийг Сангийн яам, төрийн холбогдох байгууллагуудаас мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлдэг.

Энэхүү төрийн өмчийн талаарх тайлагнал, ил тод байдал нь төрийн өмчид тавих олон нийтийн хяналт бий болгож, түүнийг удирдах, захиран зарцуулах харилцааг илүү үр дүнтэй болгоход чухал нөлөө үзүүлдэг.